# 2023-2024

## ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН

ЗОРИЛТЫН ТАЙЛАН

БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ : Х.ОТГОНЖАРГАЛ

# Товч танилцуулга

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын ñóðãóóëü íü 1956 онд байгуулагдсан. Сумын 1, 2, 3, 4 дүгээр багийн 6-14 насны хүүхдүүдийг хамруулан сургадаг бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд тус сургууль нь 151 суралцагч суралцаж байгаагаас ялгаатай хэрэгцээт 1 суралцагч, дотуур байранд 40 суралцагч амьдарч байгаа бол, 11 үндсэн багш, 2 цагийн багш, 16 ажилтантай **“Үнэлгээний үр дүнд суурилан, хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчтай нээлттэй” сургууль болох”** зорилго тавин ñóðãààëò õ¿ì¿¿æëèéí ¿éë àæèëëàãààãàà ÿâóóëæ áàéíà. Сургуулийн суралцагчдын болон багш нарын мэргэжлийн зэргийн тоон үзүүлэлтийг графикаар харуулбал:



# ЗОРИЛТ 1

**Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах**

# Сурлагын хоцрогдолыг нөхөх, арилгах хүрээнд:

1

## СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН

Сумын Хүүхэд хамгаалах хамтарсан багаас МУИС-ийн сэтгэл зүйн төгсөх ангийн оюутнуудыг сумандаа урилгаар авчирч сурагчдад сайн дурын сургалт зөвлөгөө болон ганцаарчилсан зөвлөгөөг үзүүлж байсан. Үүнд 2021 онд 7 хүүхэд, 2022 онд 31 хүүхэд, 2023 онд 65 хүүхэд үйлчилгээ авсан тоон үзүүлэлт байна. 2024 онд аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газраас мэргэжлийн сэтгэл зүйчийг долоо хоногийн пүрэв гараг бүрт тусгай хуваарийн дагуу ажиллуулж энэ онд нийт 5 удаагийн уулзалтаар 43 суралцагчийг хамруулсан байна.

2

## БИЕ БЯЛДАР, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР

Сумын нийгмийн ажилтан, сумын хүүхэд хамгаалах хамтарсан баг, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сурлагын хоцрогдолгүй суралцуулах зорилгоор дархлаажуулалтад 25 суралцагч, бие бялдрын үзлэгт 151 суралцагч, амны хөндийн үзлэг, эмчилгээнд 142 суралцагч, асуулга, сургалт нөлөөллийн 12 төрлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 328 суралцагчийг хамруулан ажилласан байна.

3

## ЦАХИМ ОРЧНЫ ТАЛААР

Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах хүрээнд нөхөх арилгах чиглэлээр 32 цахим контент бэлдсэн бол 2023 онд сум хөгжүүлэх сангийн 36 сая төгрөгийн хөрөнгөөр ЦАХИМ АНГИ, цахим хэрэглээний зардлаар АМЖИЛТ системийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Мөн 2024 онд сургуулийн нөхөн хангалтын зардлаар утасгүй сүлжээний төхөөрөмжийг суурилуулан хичээлийн байр болон дотуур байрыг цахим сүлжээнд бүрэн хамруулсан байна..

Amjilt

# Утасгүй дотоод сүлжээ байгуулах

## Санхүүгийн хуваарилалт

Сургуулийн орчинд интернэт сүлжээний асуудал тулгарч байсан. Үүнийг БШУЯ-аас хэрэгжүүлж буй “Боловсролын сургалтын байгууллагуудад утасгүй дотоод сүлжээ байгуулах” төслийн хүрээнд **20.536.000** төгрөгийн санхүүжилт бүхий тоног төхөөрөмжийг суурилуулан платформ дээр суурилсан сургалтын үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах асуудал бүрэн шийдвэрлэгдсэн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр сургуулийн орчинд интернет сүлжээний хэрэглээ илүү өргөн, хүртээмжтэй болж сургалтыг дэмжих, цахим платформоо хэрэгжүүлэх боломжтой болсон. Хичээл байр болон, дотуур байрны орчинд интернет сүлжээний бүрэн холбогдсон.



# Суралцагчдын зайн, цахим платформоор дамжуулан хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

ДҮН

Эдүтэн цахим платформын мэдээллийг танхимаар 3-4-р ангийн 31 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд суралцагчдад хичээлийн хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулж байна. 2024 оны 1 дүгээр улиралд сургууль бүхэлдээ утасгүй дотоод сүлжээнд холбогдсоноор уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд илүү хялбар болсон.

Мөн эцэг эхчүүдийг цахим хичээлд урьж компьютер дээр сургалтыг зохион явуулсан. Мөн долоо хоног бүр хамгийн олон цом, алмаз авсан сурагчдын “Хэн олон цом цуглуулах вэ?” үйл ажиллагааг Эдүтэн самбарт байршуулан урамшуулж алдаршуулан ажиллуулдаг. Эдүтэн хичээлийн чиглүүлэг хэрэглэгдэхүүнийг бэлтгэж ашиглаж хэвшсэн.

Цахим системд суурилсан англи хэлний “Pearson” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 5,6 дугаар ангийн 31 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд тухайн хичээлийн мэдлэг эзэмшилтийг дүгнэх, үнэлэх зорилгоор суралцагчдаас оношлох болон явцын шалгалтыг авч хэрэгжүүлж байна.

PEARSON MONGOLIA

5-6 ангийн англи хэлний хичээлийн цагчилсан төлөвлөлтийг боловсруулан сургалтандаа ашигласан ба суралцагчид I-XI бүлэг хичээлийн агуулгыг судлан , унших,бичих,сонсох,ярих чадварыг эзэмшсэн.

**Үр дүн:** Сургуулийн орчинд интернэт сүлжээний асуудал тулгарч байсан. Үүнийг БШУЯ-аас хэрэгжүүлж буй “Боловсролын сургалтын байгууллагуудад утасгүй дотоод сүлжээ байгуулах” төслийн хүрээнд бүрэн шийдвэрлэсэн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр сургуулийн орчинд интернет сүлжээний хэрэглээ илүү өргөн, хүртээмжтэй болж сургалтыг дэмжих, цахим платформоо хэрэгжүүлэх боломжтой болсон. 100% интернет сүлжээний асуудалгүй болсон.

**Үр дүн:** Нэгж хичээлийн төлөвлөлт, суралцахуйн зорилттой уялдуулан төлөвлөснөөр суралцагчид хичээлийн агуулгаа ойлгож авах боломжтой. Ингэснээр цахим платформдоо нэвтрээд даалгавраа хийхэд дөхөм болдог. Мөн PEARSON хөтөлбөр дээрх дасгал даалгаврыг хоёр хувааж хичээл дээрээ хийлгэсэн нь дараагийн даалгаврыг бие даан цахим орчинд хийхэд сурагчдад хялбар болж байсан.

# Суралцагчдын зайн, цахим платформоор дамжуулан хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

**EDUTEN**

3 болон 4 дүгээр ангийн эцэг эх, асран хамгаалагч нарт Эдүтэн цахим платформын танилцуулга сургалт хийсэн. Эцэг эхчүүд хүүхдүүдээ утас болон датагаар хангах тал дээр санаачлагатай идэвхтэй оролцож байсан. Сурагчдын датаны хэрэглээг 7 хоног бүр цахим хичээл орох өдөр цаг дээр бэлдэж, гэр интернетэд дата хийж өгч явуулж хэвшсэн.







Аналитикийн үр дүнг сурагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад 7 хоног бүр явцын мэдээллийг танилцуулдаг.

# Гамшгийн үеийн сургалтын тасралтгүй үйл ажиллагааг хангах хүрээнд:







## Нүүлгэн шилжүүлэлт арга хэмжээ

Монгол улсын Шадар сайдын 2021 онд баталсан "Аймаг, нийслэлд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах хуваарь, төлөвлөгөө"-ний дагуу Дорнод аймагт зохион байгуулагдсан уг үйл ажиллагааны хүрээнд НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ-ийг Баянтүмэн сумын 1-р багийн хэмжээнд 2023 оны 9 дүгээр сарын 29ний өдөр зохион байгуулж танхимын сургалтыг гамшгийн үед тасралтгүй зохион байгуулах бэлэн байдлыг хангаж сургалтын орчин, багш, суралцагчдын бэлэн байдлыг хангахад сургууль бүхлээрээ хамрагдан амжилттай зохион байгуулсан.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор 2024 оны 3 сарын 28-ны өдрийн 16:00 цагт тус сургуулийн 2-р ээлжийн бага болон дунд ангийн нийт 132 сурагч, 26 багш ажилтан, ажиллагсад хамрагдаж, аранзны бүрэн бүтэн байдлыг шалгах болон дадлага сургуулилалт хийгдлээ.

# Сурлагын хоцрогдолыг нөхөх, арилгах чиглэлээр:



## Хамтын ажиллагааны хүрээнд

"Монгол орон даяар Музейн нээлттэй өдрүүд"-ийн хүрээнд Дорнод аймгийн Музейтэй хамтран "Түүхт нутгаар аялахуй" виртуал үзэсгэлэнг сургуулийн 1-9р ангийн нийт 136 сурагч хүүхдүүдэд амжилттай хүргэлээ.

## Хөтөлбөр, төлөвлөлт

Сургууль болон багшийн зүгээс хоцрогдлыг арилгах хөтөлбөрийг илүү дэлгэрэнгүй боловсруулж сургуулийн хэмжээнд түүнийг хэрэгжүүлэх төлөвлөлтийг гарган хичээлийн жил эхлэхээс өмнө сургуулийн захиралд танилцуулан баталгаажуулан заах аргын нэгдэл болон багш нарын оролцоотойгоор хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажилласан.

## Хамтын ажиллагаа

Багш жилийн төлөвлөлтөөсөө орхигдсон агуулгаа тодорхойлж, тэдгээр агуулгаас заавал багшийн дэмжлэгтэй суралцах, мөн сурагч эцэг эх, гэр бүлийнхний дэмжлэгээр бие даан судлах агуулгыг тодруулан хамтын ажиллагааг ханган ажилласан.

# 2023-2024 оны хичээлийн жилийн улсын шалгалтын дүнг графикаар үзүүлбэл:

| № | Хичээлийн нэр | Суралцагчийн тоо | | Авбал зохих оноо | Авсан оноо | Гүйцэтгэлийн хувь | Түвшин | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалгагдах | шалгагдсан | | | | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| 1 | Монгол хэл | 17 | 17 | 510 | 363 | 71% | 0 | 0 | 0 | 0 | 8 | 4 | 4 | 1 |
| 2 | Математик | 17 | 17 | 578 | 436 | 75% | 0 | 0 | 0 | 0 | 4 | 9 | 2 | 2 |
| 3 | Байгаль шинжлэл | 17 | 17 | 612 | 429 | 70% | 0 | 1 | 1 | 0 | 8 | 1 | 5 | 1 |
| | Сургуулийн дүн | 51 | 51 | 1700 | 1228.0 | 72% | 0 | 1 | 1 | 0 | 20 | 14 | 11 | 4 |

| № | Хичээлийн нэр | Суралцагчийн тоо | | Авбал зохих оноо | Авсан оноо | Гүйцэтгэлийн хувь | Түвшин | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалгагдах | шалгагдсан | | | | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| 1 | Монгол хэл | 10 | 10 | 400 | 307 | 77% | 0 | 0 | 0 | 0 | 4 | 3 | 3 | 0 |
| 2 | Математик | 10 | 10 | 500 | 377 | 75% | 0 | 0 | 0 | 0 | 4 | 1 | 3 | 2 |
| 3 | Англи хэл | 10 | 10 | 500 | 380 | 76% | 0 | 0 | 0 | 0 | 4 | 0 | 4 | 2 |
| 4 | Байгалийн ухаан /нэгдмэл агуулга/ | 2 | 2 | 160 | 141 | 88% | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 |
| 5 | Нийгмийн ухаан /нэгдмэл агуулга/ | 8 | 8 | 400 | 285 | 71% | 0 | 0 | 0 | 0 | 5 | 3 | 0 | 0 |
| | Сургуулийн дүн | 40 | 40 | 1960 | 1490 | 78% | 0 | 0 | 0 | 0 | 17 | 7 | 12 | 4 |

# ЗОРИЛТ 2

**Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдолыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах**

# СУРАЛЦАГЧИЙН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ХҮНДЭТГЭСЭН ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГТ НИЙЦСЭН БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ТАЛААР




**Нийт 85 үйл ажиллагаа зохион байгуулагдсанаас Онцлог болохуйц үйл ажиллагаа:**

1.**”Бид Баянтүмэнгийн хүүхдүүд”** аялал хичээл
**2.**Өдөр бүр “**Өглөөний угталт**” үйл ажиллагаа
**3.“**Эелдэг байж инээмсэглэл түгээе” нөлөөллийн аян
**4.“Хоцордоггүй анги хамт олон**” сарын аян
5.**”Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”** аян
**6.“Эцэг эхийн оролцоо”**-2024 өдөрлөг
**7. “Надад санал байна”** сурагчдын нэгдсэн уулзалт
8. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танилцуулга, сургалт
9.**”Өглөөний мэдээ”** багш, сурагчдын цаг ашиглалтыг мэдээллэх хуудас
10. **“Хүн болох багаасаа”** төсөл
11. Дэвтрийн үйл ажиллагаа
12. “Оролцоод хөгжье” хүүхдийн чуулган
13. Коктейль үйл ажиллагаа

**Үр дүнд: Суралцагч**дын дунд хувь хүний онцлогийн талаар сургалт нөлөөлийн ажлыг зохион байгуулан мэргэжлийн багш нар болон бусад байгуулагатай хамтран хичээлийн жилийн туршид 151 сурагч, 11 багш, 15 ажилтан, 147 эцэг эх, асран хамгаалагчдад зохион байгуулсан. Нийгмийн ажилтны арга зүйн зөвлөлтэй хамтран сургалт, нөлөөллийн ажлыг сургуулийн хэмжээнд зохион байгуулж жендэр, үе тэнгийн дээрэлхэлт, электрон тамхины хор нөлөө сэдвүүдээр 6-9 дүгээр ангийн 57 сурагчдыг хамруулсан. Сурагчдын сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэхэд орон нутгийн төрийн захиргааны болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж хамтын ажиллагаа нэмэгдсэн жил байлаа.









# СУРАЛЦАГЧИЙН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ХҮНДЭТГЭСЭН ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГТ НИЙЦСЭН БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ТАЛААР

**“ДЭВТЭР МИНИЙ ТОЛЬ” үйл ажиллагаа**

Хамрах хүрээ: 7 хоног бүрийн баасан гарагт хуваарийн дагуу 1-9 анги
Үр дүн: 28 удаагийн 2688 дэвтэр үзэж, 675 талархлыг нааж, дэвтрийн үйл ажиллагаа сайжирсан.

**СУРГУУЛЬД БЭЛТГЭГДСЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

Хамрах хүрээ: 2023-2024 оны хичээлийн жилд 1-р ангид элсэх сурагчид

**ДЭМЖЛЭГИЙН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургуульд суралцаж буй тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах арга зүйн мэдээлэл, туршлага судлах үйл ажиллагаар Хэрлэн сумын 11-р сургуулиас

**“ҮСЭГЛЭЛИЙН БАЯР” ТАЙЛАНТ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хамрах хүрээ: 1 анги 15 сурагч, эцэг эх асран хамгаалагч-23
Үр дүн: Сурагчид хугацаандаа уншиж, бодож, сурсан мэдсэнээ эцэг эх, асран хамгаалагч нартаа танилцуулсан.

**ПҮРЭВ ГАРАГ БҮР УНШЛАГЫН ЦАГ**

Хамрах хүрээ: 1-5 дугаар ангийн 98 сурагч, 5 багш
Үр дүн: Уншлагын дундаж уншлага 38-59 үгээр ахисан үзүүлэлттэй.

**ЭСКУРС ХИЧЭЭЛ**

Хамрах хүрээ: 6-9 ангийн сурагчид
Хамтарсан байгууллага- Хилийн цэргийн 0132 дугаар анги
Үр дүн: Суралцагчид Хилийн цэргийн дугаар заставт очсноор Монгол Улсын тусгаар тогтнол, эх орныхоо хил хамгаалах, бүтээн байгуулалтад гарамгай үүрэг гүйцэтгэсэн, гавьяат үйлс бүтээсэн төр, цэрэг, нийгмийн нэрт зүтгэлтнүүд, цэрэг дайчдын амьдрал ахуйтай газар дээр нь танилцах

**ЯЛГААТАЙ ТҮВШНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ**

Хамрах хүрээ: 1,2 дугаар ангийн сурагчид
Үр дүн: Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлэх, сурлагын хоцрогдолтой суралцагчдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдэд сурах боломжийг бүрдүүлэн сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган ажилласан.

**ЖАРГАЛТАЙ, ГАЙХАЛТАЙ**

Хамрах хүрээ: 1,9 дугаар ангийн 40 сурагчид
Зохион байгуулагч: Юнител
















# Сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх хүрээнд

1



## Сургалтын орчин

Сумын ОНХ сангийн оруулалт 10 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжсэн Англи хэл, түүх нийгмийн ухааны анги, монгол ёс заншлын танхимын орчин, хэрэглэгдэхүүн

2



## Номын фонд нэмэгдүүлэх

Орон нутгийн хөгжлийн сангийн 5 сая төгрөгний төсөвт өртөгтэй ажлын хүрээнд номын тавиур 1 ширхэг, хувь хүний хөгжил, танин мэдэхүйн, дэлхийн болон монголын орчин үеийн уран зохиолын ном, мэргэжлийн гарын авлага зэрэг 141 ширхэг номоор баяжив.

3



## Цахим орчны сайжруулалт

Байгууллагын төсвийн нөхөн хангалтын зардлын 7.9 сая төгрөгийн хөрөнгөөр УХААЛАГ САМБАР-тай болж техник хэрэгсэл, цахим ангийн орчинг сайжруулан ажиллаж байна.

4



## Сургалтын орчин

Аймаг, сумын ОНХС, сумын хөрөнгөөр сурагчийн ширээ сандлыг шинэчлэх ажлын хүрээнд 17.908.430 төгрөг хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн.

# ЗОРИЛТ 3

**Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох**

# БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД СУУРИЛСАН БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙГ БИЙ БОЛГОЖ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНД СУУРИЛАН БАГШ АЖЛЫН БАЙРАНДАА МЭРГЭЖЛЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХ, УР ЧАДВАРТ ГАРСАН АХИЦ, ҮР ДҮНГ ТООЦОХ

**Үр дүн:** Сургуулийн менежментийг сайжруулах, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд энэ хичээлийн жилд 15 төрийн байгууллагатай хамтран 638 эцэг эх, асран хамгаалагчтай /давхардсан тоогоор/ оролцоог нэмэгдүүлж ажилласан байна.

**1**

2022-2023 оны хичээлийн жилийн багшийн болон сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ түүний мөрөөр хэлэлцүүлэг сургалт

**2**

“Сургуулийн менежментийг дэмжих” арга зүйн зөвлөмж Гүйцэтгэлийн үнэлгээг харьцуулсан тоон болон чанарын үнэлгээг хийж, сурлагын хоцрогдлыг арилгах, бууруулах төлөвлөлт хийсэн. Энэ хичээлийн жилд 11 багш бүрэн гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан.

**3**

Анализ датаны хүрээнд багш нарын дунд хэлэлцүүлэг



**4**

“Ойлгож уншъя“, “Судалгаат хичээл” мэргэжлийн хөгжлийн бүлэг
Хамрах хүрээ: бага болон дунд ангийн багш нар

**5**

“Хамтын хөгжил- бидний оролцоо” эцэг эх, асран хамгаалагч нарын уулзалт өдөрлөг
“Хамтын хөгжил- бидний амжилт” эцэг эх, асран хамгаалагч нарын тайлант өдөрлөг

**6**

V бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан

1. “Сурагч солилцоо”
2. “Хамтдаа оролцъё, суралцъя, хөгжье” албан хаагчдын өдөрлөг








# БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ГАРСАН АХИЦ

LEARNING

1.Багш мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө

2.Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Aplus.mn сургалтын платформд 26 сургалт

3. Утасгүй сүлжээний суурилуулалт

**Багшийн тасралтгүй хөгжлийг хангах**

1. “ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ” хэлэлцүүлэг, сургалт Хамрах хүрээ: 29 багш, ажилтан

4. Үндсэн сургалт 1

5. Аймаг орон нутгийн 32

6. сум, орон нутгийн 34

7. Аймгийн мэргэжлийн судлагдахуунд суурилсан МХБ-ийн сургалт - 12

**Багшийн тасралтгүй хөгжлийг хангах санхүүжилтийн зардлаар**

2.Aplus.mn модуль сургалтын төлбөр

8.Мэргэжлийн хөгжлийн бүлгийн суралцахуйд суурилсан судалгаат хичээл - 8

9.“Багш хөгжлийн цаг” ажлын байрны сургалт -27

10. ”Ээлжит хичээл- Хэрэглэгдэхүүн” 1 сарын аяныг хэрэгжүүлсэн

Багшийн тасралтгүй хөгжлийг хангах санхүүжилтийн зардлаар

2. “Багш солилцоо” үйл ажиллагаа-4

12”Бага ангийн багшийг дэмжих төсөл”-д бага ангийн багш Б.Сосорбурам

13. Үндэсний бичгийн сургалт-15 багш

14.Авлигаас ангид төрийн алба 3 түвшний сургалт

БЕГ-ийн ЕБС-ийн багш, удирдах ажилтны эхний, 5, 10 дахь жилийн үндсэн сургалт -1

15. Ковид-19 цар тахлын улмаас хүүхдийн анхаарал тогтворжилтын хугацаа багасч хичээлд оролцох оролцоо, анхаарал төвлөрлийг нэмэгдүүлэх зорилгоор анги удирдсан багшаар дамжуулж эцэг эх, суралцагчдын хичээлд оролцох оролцоог сайжруулах арга зүйн дараах зөвлөмж

НИЙТ 281

**ҮР ДҮН:**

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлын хүрээнд багш бүр багш мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан боловсруулж, олон төрлийн сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн хөгжлийг дэмжсэн сургалт, хэлэлцүүлэг уулзалт, зөвлөгөөн, уралдаанд идэвхтэй хамруулсанаар багш нарын ажлын үр дүн нэмэгдэж, сайжирсан.



# ЗОРИЛТ 4

**“Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх**

# “Тэргүүлэх багшийн манлайлал”

Сурагчдын номтой нөхөрлөх,унших дадал хэвшлийг нэмэгдүүлэх Түүх, уран зохиолын дурсгал монголын нууц товчооны агуулга утга санааг танин мэдэж, монгол соёлын өвийг судлан, бахархан дуурайх үзлийг бий болгох зорилготой







- **6-9 анги** — Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ?” Алтан хонх танин мэдэхүйн тэмцээн
- **6-9 анги** — “Монголын нууц товчооны нууцад нэвтрэхүй ”дүрийн тоглолт,асуулт хариултын уралдаан
- **6-9 анги** — “Би хэн бэ?” Монголын нууц товчоо-ны дүр тайлбарлах
- **3-5 анги** — Би эх орондоо хайртай ” Бүтээлч ажил санаачлан хийх
- **3-5 анги** — “Хэрвээ би Ерөнхийлөгч байсан бол ....” сэдвээр видео бичлэг
- **1-2 анги** — “Миний эх орон ” сэдэвт баримлын шавраар бүтээл хийх уралдаан

# 02 Үйл ажиллагааны санаа

## Төлөвлөлт

“ТЭРГҮҮЛЭХ БОЛОН ЗААХ АРГАЧ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ” үйл ажиллагааны хүрээнд жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бага, дунд ангийн 1, дунд ангийн 3 багшийн хүрээнд нээлттэй хичээлийг зохион байгууллаа. ТНУ-ны багш Г.Өнөржаргал “Тонгоруу сургалтын арга”, А.Алтан-Од “Физикийн туршилтат” хичээл, бага боловсролын багш , дунд ангийн багш нарт ТДХ, EGRA, EGMA арга зүйг түгээн дэлгэрүүлж, нээлттэй хичээлийг амжилттай зохион байгуулж, оролцсон.

01

02

Ахмад үеэ хүндэтгэх,тэдний амьдралын арга туршлагаас суралцах, хөдөлмөр гавъяа зүтгэлийг таниулах даган дуурайх суралцах үүднээс **”Зочин багш**” ярилцлагыг ахмад багш Т.Бадамгарав багштай хамтран зохион байгуулж, 15 багш, дунд ангийн нийт дунд ангийн суралцагчдын 95% хамруулллаа.





Бага боловсролын багш Б.Сосорбурам багш мэргэжлийн зэрэггүй хоёр багшид ажиллах хугацаандаа хуримтлуулсан өөрийн арга зүй, туршлагаа түгээн дэлгэрүүлж, сургалт хийн, 2 удаагийн нээлттэй сургалт зохион байгуулсан.

03

# ЗОРИЛТ 5

**Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах**

# Ажлын байранд зерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд




## Багшийг алдаршуулах, урамшуулах

### Шагнал, урамшуулал

Монголын багш нарын 57 дахь, Дэлхийн багш нарын 29 дэх баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 10 дугаар сарын 4ний өдөр аймгийн Баярын хуралд оролцож бага ангийн багш Т.Энхжаргал, биеийн тамирын багш Ж.Од, дотуур байрны багш О.Долгорсүрэн нар БШУ-ны яамны “Жуух бичиг”-ээр шагнагдсаныг гардан авсан.

Сумын ИТХ-ын 2023 оны хуралдаанаас Ерөнхий боловсролын сургуулиас амжилт үзүүлсэн сурагч, бэлтгэсэн багшийг урамшуулах хөтөлбөр батлагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 12 дугаар сард 2 багшийг урамшуулалд хамруулан ажилласан.

## Ажлын байрны тав тух

Сум хөгжлийн сангийн хөрөнгөөр ажлын байрны тав тухыг нэмэгдүүлэх хүрээнд 1 сая төгрөгийн санхүүжилтээр 2 ширхэг сэтгүүлийн ширээ авч сургуулийн орчинд байршуулан ажиллаж байна.

## Ажлын байрны стрессийг бууруулах, эзрэг орчин бүрдүүлэх

Аймгийн Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын газраас сэтгэлзүйчийг урилгаар авчирч “Ажлын байрны стресс менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 23 албан хаагчийг хамруулсан байна.

# БАГШ ТӨЛӨӨЛӨГЧ, БАГШИЙГ ДЭМЖИХ

## VIII их хурлын төлөөлөгч-Бага ангийн багшийг дэмжих







### Багшийн дуу хоолой

Монголын багш нарын VIII их хуралд төлөөлөгч сонгон оролцуулах үйл ажиллагааг бүс болгон зохион байгуулсанд тус сургуулийн биеийн тамирын багш Ж.Од сонгогдож, сонгосон сургуулийн багш нарын ажлын байранд тулгамдаж буй асуудлыг хүргэх хүргэх үйл ажиллагаанд оролцлоо

### Бага ангийн багшийг дэмжих төсөл

Дорнод аймгийн Засаг даргын санаачлагаар аймгийн хэмжээний бага боловсролын багш нарыг дэмжих төслийг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол Шинжлэх Ухааны газар хамтран амжилттай зохион байгууллаа. Энэхүү уралдаанд тус сургуулийн бага ангийн багш Б.Сосорбурам багш шилдэг 28 багшид шалгарч БАТЛАМЖ, орон сууцны урьдчилгаа болох 20 сая төгрөгийг гардан авлаа.

# ЗОРИЛТ 06

**Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүрээмжийг нэмэгдүүлэх, сурах хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох**

# ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТИЙН ТАЛААР

Хүүхдийн аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийн эрх үүрэг, электрон тамхины хор нөлөө сэдвийн хүрээнд нийт 8 удаагийн сургалт

**256**

**40**

Дотуур байрны хүүхдүүдэд Хүүхдийн аюулгүй байдал сэдвээр Чадамжийн эрин академийн тэргүүн н.Эрдэнэтунгалаг мэдээлэл хийлээ.

“Үе тэнгийн дээрэлхэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлье” Жендэрт суурилсан хүчирхийлэл сэдвийн хүрээнд нийт 11 удаагийн сургалтад

**689**

**5209**

Цагдаагийн Ерөнхий газар, Боловсролын Ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” сарын аяны хүрээнд сургуулийн нэгдсэн группт 31 удаагийн мэдээ мэдээллийг

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбарын зөвлөлийн санхүүжилтээр сурагчдын аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Монголын цахилгаан холбооны Дорнод аймаг дахь салбар “Илтгэлтэй утас”-ыг суурилууллаа.

**1**

**НИЙТ 6195**

**ҮР ДҮН**

Үйл ажиллагааны үр Эцэг эх олон нийт аяны талаар мэдээ мэдээлэлтэй болохоос гадна суралцагчид үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх мэдээ мэдээллийг түлхүү түгээсэн. Сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлийг бууруулах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, аюулгүй байдал хангагдсан. Хүүхэд бүр дээрэлхэлийн хор уршгийн талаар мэдлэгтэй болсон.
















# ЗОРИЛТ 07

**Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцох**

# Сургуулийн гадна болон дотоод орчны аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ

2023-2024 хичээлийн жилийн эхэнд сургуулийн гадаад болон дотоод орчны аюулгүй байдал, гамшгийн эрсдлийн үнэлгээг нийгмийн ажилтан, сурагчийн төлөөлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр баг бүрдүүлэн хийж гүйцэтгэлээ.

Сургууль, дотуур байрны орчны эрсдлийн үнэлгээг 37 асуулгын дагуу үнэлж дүгнэлтийг гарган, анхаарах шаардлагатай, засаж сайжруулах хэрэгцээтэй байгаа зүйлийг жагсаалтыг гарган хэрэгжилтэд анхааран ажилласан. Хичээлийн жилийн төгсгөлд буюу 5 дугаар сарын 2нд 24 асуулгын дагуу үнэлгээг хийж “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн.

Дотоод хяналт

- **Зөвлөлийн уулзалт, ажлын чиглүүлэг-1**
- **Add content**
- **Add content**

# “Хамтдаа шалгая, хамгаалъя”

## аяны хүрээнд

- Аюулгүйн зураглал

Бүх суралцагчид гэрээсээ сургууль хүртэлх аюулгүйн зураглал гаргасан.

- Тулгамдаж байгаа ...суудлаа ...орхойлох

Сургуулийн эд хогшилыг хайрлах, гамтай ашиглах

Сумын тоглоомын талбайг эвдрэлгүй болгох

Сургуулийн орчинд тоглоомын орчин нэмэгдүүлэх

- Гамшгийн үеийн бэлэн байдал

Дотуур байрн... сурагчдад гамшгийн үеийн бэлэн байдлыг дадлагыг улирал бүр хийж хэвшсэн

- Хүүхэд хамгаалал

Сургуулийн хүүхдийн зөвлөл сумын хүүхэд хамгаалах хамтарсан багт тулгамдаж буй асуудлаа тавьж шийдвэрлүүлсэн.

# ЗОРИЛТ 8

**Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ**

# Энэ хичээлийн жилийн онцлох үйл ажиллагаа





**Эссэ бичих чадварыг дэмжих**



**“Шүдний өвчлөлгүй Баянтүмэн” зорилтот арга хэмжээ**

### Алдартныг алдаршуулахуй

Монгол улсын Дорнод аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 6-р хуралдааны тогтоолоор Нэрт соён гэгээрүүлэгч бичгийн их хүн Онход овогт С.Жамъянгийн нэрэмжит болсон. Зүтгэлтнүүдийг алдаршуулах, үйлсийг таниулах үүднээс жил бүр 7-9 ангийн сурагчдын дунд эссэ болон илтгэлийн уралдаан зохион байгуулж хэвшээд байна.

### Эх оронч үзлийг төлөвшүүлэх

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан гол усаа хайлан хамгаалах уламжлалт зан үйл болон Баянтүмэн сумын усны мөн чанар, усаа хэмэх арга зэргийг **тусгасан “Эх орноо хайрлах нь энгийн үйлдлээс эхэлнэ”** сэдвээр илтгэл, эссэний уралдаан зохион байгуулж, 7-9 ангийн сурагчдын 17 ба 68% хамрагдлаа.

### Амны хөндийн үзлэг, эмчилгээ

Сумын Эрүүл мэндийн төв 2023 онд шүдний бор машинтай болсноор сумын удирдлагуудын зүгээс Шүдний өвчлөлгүй Баянтүмэн” арга хэмжээг хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг урилгаар ажиллуулан нэн тэргүүнд хүүхдийн шүдийг эрүүлжүүлэх арга хэмжээг 11-р сарын 25ны өдрөөс эхлэн зохион байгуулж, сургуулийн нийт суралцагчдын 98 хувийг үзлэгт хамруулж, сургуулийн бүх суралцагчийн шүдийг эрүүлжүүлэн ажилласан байна.

# Энэ хичээлийн жилийн онцлох үйл ажиллагаа

## Танхимын бус үйл ажиллагаа

“БИД БАЯНТҮМЭНГИЙН ХҮҮХДҮҮД” аялал

хичээл үйл ажиллагаа

## Судалгаат хичээл

“Чанартай сургалтаар нээлттэй хүүхдийг төлөвшүүлэх” зорилтын хүрээнд багш нарын дунд “Судалгаат хичээл” –ийг бага ангийн 5 багш, дунд ангийн 6 багш нарыг оролцуулан 8 хичээлийш заасан. Судалгаат хичээлээр багш нар сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэж, бусад багш нартаа түгээн дэлгэрүүлж байна.

## Чанартай хичээл төлөвлөлт

Багш нарын ээлжит хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хичээл төлөвлөлт, хэрэглэгдэхүүний бэлтгэл зэргийг сайжруулах аян, уралдаан



## Replace text

click here to add text click here to add text click here to add text， click here to add text

## Үндны усны цэвэршүүлэх төхөөрөмж

Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн ундны усны эрүүл аюулгүй байдлыг хангах хүрээнд сум хөгжлийн сангийн хөрөнгөөр Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна.

# 2023-2024

А Н Х А А Р А Л  Х А Н Д У У Л С А Н  Т А
Б Ү Х Э Н Д Э Э

# БАЯРЛАЛАА